

МЭДЭЭЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ҮНДЭСНИЙ ПАРКЫН 2021 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Д/д	Ажлын чиглэл	Ажлын үндсэн ангилал	Хариуцах нэгж	Биелэлт	Хүрэх үр дүн, КРІ	Биелэлт хувиар	
1	МТ-ийн Гарааны бизнесийн эко орчинг бүрдүүлэх, инкубаторын үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаа						
1.1	Инкубаторын үйл ажиллагаа	1.1.1.	Элсэлт, төгсөлт, зохион байгуулах	ТУСМХ	Элсэлт: Нийт 2 удаагийн (40, 42) элсэлтэд 10 иргэн, баг, 9 компани оролцсоноос 5 иргэн, баг, 2 компани буюу нийт 7 оролцогч сонгон шалгаруулалтад тэнцэв. Тэнцсэн компаний 4 нь Аппликейшн хөгжүүлэлт, 3 нь Програм хөгжүүлэлтийн чиглэлээр байна. Төгсөлт: Мэдээллийн технологийн инкубаторын үйл ажиллагааны журмын 7.1 заалтыг үндэслэн инкубаторын 7 компанийг төгсгөж, тус журмын 8.1.2 заалтыг үндэслэн 2 компанийг хугацаанаас өмнө хасав.	2 удаагийн элсэлт зохион байгуулж, шинээр элсэгчдийн тоог нэмэгдүүлсэн байна. 1 удаагийн төгсөлт зохион байгуулж, олон нийтэд мэдээлсэн байна.	100
		1.1.2.	хагас жил, сар тутмын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж үнэлгээ өгөх,	ТУСМХ	Сар тутмын үнэлгээ: Сар тутмын үнэлгээг нийт 12 удаа зохион байгуулав. 2021.10 сарын байдлаар инкубаторын компаниудын <u>нийт орлого 1,131,062.837.60, нийт зардал нь 848,777.428.0, Үлсад төлсөн татвар, хураамж 89,947.173.00, бодит хөрөнгө оруулалт нь 173,626.691.00</u> төгрөг байна. Нийт ажлын байрны тоо: 164 Хагас жил: Хагас жил тутмын үйл ажиллагааны хяналт-шинжилгээ, үнэлгээг 7 удаа зохион байгуулж давхардсан тоогоор 24 компани хамрагдсан бөгөөд үнэлгээгээр 2 компани хасагдаж, 22 компани инкубаторын үйлчилгээг үргэлжлүүлж байна.	Хагас жилийн үнэлгээ 7 удаа, сар тутмын үнэлгээг 12 удаа зохион байгуулсан байна.	100

		Инкубаторын цогц үйлчилгээ үзүүлэх, /Инноваци, оюуны өмч, хууль эрх зүй бусад сургалт, хэрэглэгчдийн уулзалт зохион байгуулах бусад/	ТУСМХ	<p>Хэрэглэгчийн уулзалт:</p> <p>1. Дахин боловсруулах, хог цуглуулах аппликейшний хэрэглэгчийн судалгаа хийх зорилгоор ПТС ХХК-тай хамтран дахин боловсруулах үйлдвэртэй хэрэглэгчийн уулзалт зохион байгуулав.</p> <p>2. ТӨБЗГ-ын актлагдсан бараа, бүтээгдэхүүний зарын вэб сайт хийх талаар уулзалтыг Робот софт ХХК, Эс рэй софт ХХК, Юникүе повер теч ХХК, ПТС ХХК-иудтай хамтран зохион байгуулав.</p> <p>3. Робот софт ХХК -тай хамтран ХААИС-ийн багш, оюутнуудад бүтээгдэхүүн, үйлчилгээ болон түншлэлийн хөтөлбөрөө танилцуулав. Оролцогчдын тоо: 50</p> <p>4. "Digital nation"-2021 экспод инкубаторын 10 компанийн бүтээгдэхүүн, үйлчилгээг олон нийтэд сурталчлав.</p> <p>Захирлуудын уулзалт: Захирлуудын уулзалтыг нийт 12 удаа зохион байгуулав. Уулзалтад оролцогчдын ирцийн биелэлт: 74%</p> <p>Сургалт: Санхүүгийн чиглэлийн 4, Маркетингийн чиглэлийн 2 нийт 6 удаагийн сургалт зохион байгуулж, 14 компанийн давхардсан тоогоор 56 ажилтан хамрагдав.</p> <p>Бусад арга хэмжээ: Инкубатор компаниудын хамтын ажиллагааг нэмэгдүүлэх зорилгоор "Өглөөний цай", "Чингэлтэй хайрхан"-ны алхалт, "Спортын өдөрлөг" зэрэг арга хэмжээнүүдийг зохион байгуулав.</p>	Хэрэглэгчдийн уулзалт 4 удаа, захирлын уулзалт 12 удаа, цогц үйлчилгээ компани тус бүрт хүргэн чиглэл бүрээр нийт 6 удаа сургалт, арга хэмжээ зохион байгуулсан байна.	100
	1.1.3		ТУСМХ	<p>Оюуны өмчийн зөвлөх үйлчилгээ: Инкубаторын 7 компанийн барааны тэмдэгт, 1 компанийн программ хангамжийг зохиогчийн эрхээр бүртгүүлэхээр Оюуны өмчийн газарт мэдүүлэг гаргасан. (Оюуны өмчийн газарт шүүлтийн хугацаан дээрээ байгаа учир 2022 онд мэдүүлгийн хариу гарна.)</p>	Инкубаторын компаниудаас 3 компанийг ОӨ-ийн зөрчилгүй байгууллага болгон бараа бүтээгдэхүүнийг патентжуулсан байна.	100
	1.1.4	Холбогдох бичиг баримтыг боловсруулах, шинэчлэх, хөтлөлт хийх	ТУСМХ	<p>Инкубаторын хүрээнд 5 журам шинэчилж, 1 гарын авлага гарган батлуулав. Үүнд:</p> <p>1.Мэдээлэл технологийн инкубаторын үйл ажиллагааны журам</p> <p>2.Мэдээллийн технологийн инкубаторын компаниудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж, үнэлгээ өгөх журам</p> <p>3."Ахисан" түвшний инкубаторын журам</p> <p>4.Инкубаторын сонгон шалгаруулалтын журам</p> <p>5.Инкубатор компаниудын үйл ажиллагаанд сар тутам хяналт тавьж, үнэлэлт дүгнэлт өгөх журам</p> <p>6.Инкубаторын элсэгчдэд зориулсан гарын авлага</p>	Дэвшилтэт санаа дээр үндэслэн журам холбогдох гэрээ, дүрэмд өөрчлөлт оруулан хэрэгжүүлэн ажилласан байна.	100

1.2	ITHub-ийн үйл ажиллагаа	Технологид суурилсан бүтээлч сэтгэлгээг дэмжих, арга хэмжээ зохион байгуулах, төвлөрлийг бий болгох	ИТСХХ	1. Startup World Cup дэлхийн технологийн гарааны бизнес шалгаруулах тэмцээнийг хамтран зохион байгуулж амжилттай оролцсон Onefit ХХК-г инкубаторын 2 жилийн хөтөлбөрт хамруулан, нийтдээ 60.000.000 төгрөгийн хөнгөлөлт үзүүлж гэрээ байгуулав.	4 удаагийн Питч зохион байгуулж, шилдэг санааг шалгаруулан 2-3 баг, иргэнд дэмжлэг үзүүлсэн байна.	80
				2. "Ковидын дараах маркетинг" сургалтыг Түмэн Тэрэг Тээх ХХК-тай хамтран зохион байгуулсан бөгөөд 10 инкубаторын компанийн 50 төлөөлөл оролцон, 4 компани pitch танилцуулсан.		
				3."Эко байгаль, Эко систем түүний ач холбогдол, үр нөлөө" сэдвийн хүрээнд подкаст хийж гүйцэтгэсэн бөгөөд зураг авалт, бичлэгийн танхимаар ханган хамтран ажилласан.		
	ИТСХХ	1.Царай таних системийн судалгаа хийн удирдлагад танилцуулсан. 2.QR кодын бичилтийн ажил хийгдэж QR кодоор ITHub-д үйлчлүүлэгчдийн мэдээллийг бүртгэж нэвтрүүлсэн.	Хэрэглээний программ хангамж руу чиглэсэн 2 бүтээгдэхүүн үйлчилгээг туршиж, нэвтрүүлнэ.	50		
	1.2.2	Үйл ажиллагааг өргөтгөх, арга хэмжээ зохион байгуулах тав тухтай оффис, номын номын үйлчилгээг өргөжүүлэх	ИТСХХ	1. Түмэн Тэрэг Тээх ХХК-тай хамтын ажиллагааны хүрээнд "This is Marketing" номын танилцуулах уулзалт зохион байгуулж 40 гаруй хүн хамрууллаа. Номын үзэсгэлэн дараах байдлаар зохион байгуулав. 2. МТИШ-ын номыг танилцуулах ажлын хүрээнд МТҮП-ын гадна талбайд номын өдөрлөгийг 3 өдөр зохион байгуулж, Өглөөний гудамж хөтөлбөр арга хэмжээнд -1 өдөр танилцуулав.	МТ-ийн шинээр гарсан ном, гарын авлагыг танилцуулах уулзалт, семинар 1 удаа зохион байгуулсан байна.	100
			ИТСХХ	Номын санд МТ-ийн Бизнес инкубаторт элсэгчдэд зориулсан гарын авлага, МТҮП-ын Түүхэн хэлхээс ном, МТҮП танилцуулга, Инкубатор компаниудын гарын авлага, Бизнес инкубаторын элсэгчдэд зориулсан гарын авлага, Шалгуулагч болон суралцагчдад зориулсан гарын авлага нийт 6 ном, гарын авлагаар баяжуулсан. Номын санд МТ-шинжлэх ухааны -437ш, Эдийн засгийн 527ш, Техникийн ном-65ш, Хэл шинжлэл-1218ш, Байгалийн ухаан-189ш, Эрүүл мэнд-488ш нийт 20,904.000₮ төгрөгийн өртөгтэй 2924 ширхэг ном, сэтгүүл, гарын авлага байна.	МТ болон Гарааны бизнес эрхлэгчдийн гарын авлага, ном сурах бичгээр номын санг баяжуулсан байна.	100

				ИТСХХ	Цахим номын фондыг бий болгох ажлын хүрээнд цахим 100 номын фонд үүсгэсэн бөгөөд МТИШ, ТОПСИТ, ICDL шалгалтын, ном болон гарын авлагыг апп дээр байршуулсан	Цахим номын фондыг бий болгож, 100 бүтээл бүртгэх, 2-4 цахим ном унших төхөөрөмжтэй болсон байна.	100
				ИТСХХ	1.Гарааны компаниудын маркетингийн үйл ажиллагааг дэмжих болон номын сангийн баяжилт, үйлчилгээг хөгжүүлэх чиглэлээр Түмэн Тэрэг Тээх ХХК-тай хамтран ажиллах гэрээ байгуулсан бөгөөд тус компани IThub 1-д байрлан үйл ажиллагаа явуулж байна. 2. IThub 2 дээр 6 сарын бартерын гэрээтэй 2 иргэн үйлчлүүлж байна. Гэрээний хүрээнд Scrach -ын сургалтад багшаар ажилласан.	Дундын оффис ашиглалтын 10 ширээг 100% ашиглалттай болгож, танхимын доторх сул зайг ашиглаж шинээр 10 ширээ байрлуулан үйл ажиллагааг өргөжүүлсэн байна.	100
				ИТСХХ	ITHub-д Цаг бүртгэлийн QR кодыг үйлчлүүлэгчдэд нэвтрүүлсэн бөгөөд танхимыг 100% ашиглалттай болгосон. IThub-д давхардсан тоогоор ширээ ашиглалт болон инкубатор компаниуд хурал, ярилцлага, уулзалт зохион байгуулж нийт 360 үйлчлүүлэгч үйлчлүүлсэн бөгөөд Бартераар 5,037,000₮, Төлбөртэй-565,000₮, Кофе-71ш /185,000/ нийт- 5,787,000₮ орлоготой ажиллав.	Танхимын ашиглалтыг сайжруулах зорилгоор цаг бүртгэлийн шинэ системийг нэвтрүүлэн үр ашгийг нэмэгдүүлсэн байна.	100
				ИТСХХ	Үйл ажиллагааг өргөжүүлэн IThub 2-ийг байгууллагын байрны 1-р давхарт 100м2 талбайд байгуулсан бөгөөд гадаад, дотоод тохижилтын төсөл боловсруулсан. IThub2-ийн тохижилтын хүрээнд оффисын хөшиг 5ш "Шар угалз" ХХК хийж гүйцэтгүүлж, ус цэвэршүүлэгчийг холбуулж, Дулааны асуудлыг боломжид тулгуурлан 500вт паран тень холбуулж цахилгааны цагийн хязгаарлалтыг суурилуулсан.	Гадаад, дотоод тохижилтыг сайжруулж, үйлчилгээний тав тухтай орчныг бүрдүүлсэн байна.	100
	1.2.3	Холбогдох бичиг баримт боловсруулах, шинэчлэх, хөтлөлт хийх		ИТСХХ	IT HUB-н шинэчилсэн журам, Сайн дурын ажилтан ажиллуулахтай холбогдох дүрэм, санамж бичиг, IThub1 болон 2 -ын эд хөрөнгийн нэгдсэн бүртгэл зэргийг боловсруулав.	Дүрэм, журам, гэрээ болон бусад бичиг баримтын эмхтгэл гарган олон нийтийн хүртээл болгосон байна.	100
2	Хүний нөөцийн ур чадварыг хөгжүүлэх, дэмжих үйл ажиллагаа						
2.1	МТ-ийн мэргэжилтнүүдийг ОУ-д хүлээн зөвшөөрөгдөх боломжийг бүрдүүлэх	2.1.1.	МТИШ-ын бэлтгэл ажиллагааг хангах, зохион байгуулах, тайлагнах, хамтын ажиллагаа өрнүүлэх, сургалт семинар зохион	ТУСМХ	МТИШ-ыг 5, 11-р саруудад зохион байгуулж, нийт 113 хүн бүртгүүлснээс 100 шалгуулагч хамрагдаж, 22 шалгуулагч тэнцэв. Шалгуулагчдын тоог 2020 онтой харьцуулахад 25.6%-иар буурсан бол тэнцэгчдийн тоо 6%-иар өссөн үзүүлэлттэй байна.	МТИШ-ийг 2 удаа зохион байгуулж 160-180 хүртэл шалгуулагч хамруулсан байна.	65

		байгуулах	<p>МТИШ-ын туршилтын шалгалтыг Говь-Алтай аймгаас 10, Увс аймгаас 36, Завхан аймгаас 20 нийт 66 шалгуулагч хамруулан зохион байгуулсан бөгөөд шалгуулагчдын дундаж оноо 50%-д хүрэхгүй байгаа нь Хөдөө орон нутагт шалгалтын нэвтрүүлж холбогдох сургалтыг зохион байгуулах зайлшгүй хэрэгцээ байгааг илтгэж байна. Шалгалтаас гарсан үр дүнг байгууллага тус бүрт танилцуулан, санал зөвлөмж өгөв.</p>	Хөдөө орон нутагт 1 удаа туршилтын шалгалт зохион байгуулсан байна.	100
			<p>Япон улсын IPA байгууллагын дэмжлэгтэйгээр Говь-Алтай, Увс, Завхан аймаг, МТҮП-ын инкубаторт компаниуд, МУИС-ийн оюутнууд болон Steppe holding ХХК гэх мэт 5 газар "МТ-ийн инженерийн шалгалт"-ыг танилцуулах семинар зохион байгуулав. Семинарт нийт 281 оролцогч хамрагдав.</p>	Шалгалтыг танилцуулах семинар 1 удаа зохион байгуулж нийт 300-400 хүн хамруулсан байна.	95
			<p>Суурь шалгалтад бэлтгэх сургалтыг онлайн-аар зохион байгуулж, 24 суралцагч хамруулав. Сургалтын 10 өдрийн контентыг видео хэлбэрт оруулсан бөгөөд зохиогчийн эрхийн асуудалтай холбоотойгоор 2021 онд олон нийтэд цацаагүй.</p>	Шалгалтад бэлтгэх сургалт зохион байгуулж 20 дээш суралцагч хамруулсан байна.	100
			<p>EDM буюу ИТРЕС-ийн гишүүн орнуудын удирдлагуудын 14 дэх удаагийн уулзалтад 8 сарын 24, 25-ны өдрүүдэд онлайн-аар оролцов. Уулзалтад нийт 6 орны 31 төлөөлөгч оролцов. Уулзалтаас гарсан үр дүн: 1. Шалгалтын хуваарь: 2022.04.24, 2022.10.23, 2023.04.30, 2023.10.22 - Удирдлагуудын уулзалт (EDM)-ын хуваарь: 2020.08.30 – 31-ний хооронд Вьетнам улсад, 2023.08 сарын сүүлээр Монгол улсад тус тус зохион байгуулагдах тов гарлаа. 2. Асуулт боловсруулагчдын уулзалт (QFM): 2022.06.08-10-ны хооронд Монгол улсад, 2022.11.30 – 12.02-ны хооронд Филиппин улсад тус тус зохион байгуулагдах тов гарлаа. 3. Covid-19 цар тахалтай холбоотойгоор шалгалтын хугацааг дөрвөн долоо хоног сунгах боломжтой бөгөөд түүнээс цааш сунгагдвал шалгалтыг гишүүн орнуудын хэмжээнд нийтээр нь цуцална. 4. Суурь шалгалтын өдрийн шалгалтад 7 асуултад хариулдаг байсныг 5 асуулт сонгож хариулдаг болно.</p>	Шалгалттай холбоотой олон улсын хурал, семинарт оролцох, зохион байгуулах ажлыг жилд 1 удаа хийж үр дүнг танилцуулсан байна.	100

			<p>1. ОУ-ын асуулт боловсруулагчдын 31, 32 дахь удаагийн уулзалтад онлайнгаар оролцож, МТ-ийн инженерийн шалгалтын зөвлөл (ITPES)-д нийт 41 асуулт хандивлав. Монгол улс 2021 онд нийт 16 асуулт тэнцүүлж, чансаагаараа гишүүн орнуудын хэмжээнд 3-р байрт шалгарав. Тэнцсэн асуултын тоог өмнөх онтой харьцуулахад 6,6% -иар нэмэгдэв.</p> <p>2. МТИШ, ТОПСИТ шалгалтад тэнцэгч, TopGun хөтөлбөрийн оролцогчийг АБҮЗ-д орж ажиллах хүсэлт тавьсны дагуу 2 гишүүн нэмэгдэж нийт 17 гишүүнтэй үйл ажиллагаагаа явуулж байна.</p>	Шалгалтын асуулт хандивлах тоо, чанарыг өмнөх оноос 10 хувиар нэмэгдүүлсэн байна.	85
			<p>1. Паспорт шалгалтад бэлтгэх гарын авлагыг 500 ширхгийг "Хөх монгол принтинг" ХХК-иар хэвлүүлэн худалдаанд гаргасан бөгөөд 71 ширхэг борлуулагдсан байна.</p> <p>2. Мэдээллийн технологийн инженерийн суурь шалгалтад бэлтгэх номын VOL1 буюу технологийн хэсгийг орчуулж, дуусгав. Орчуулгыг хянах ажил 5%-тай явж байна. Тус ном нь 7 бүлэг 476 хуудастай.</p>	Ном гарын авлага гаргах ажлыг үргэлжлүүлэн МТИШ-ын суурь шалгалтанд бэлтгэх номыг орчуулан гаргаж, олны хүртээл болгосон байна.	80
2.1.2.	ICDL бэлтгэл ажиллагааг хангах, зохион байгуулах, тайлагнах, хамтын ажиллагаа өрнүүлэх	ТУСМХ	<p>1. ICDL буюу "Компьютерын хэрэглээний гэрчилгээ олгох" шалгалтыг 1 удаа зохион байгуулж, 12 шалгуулагч хамрагдсан бөгөөд 8 шалгуулагч тэнцсэн.</p> <p>2. ICDL "Digital Challenge 2021" тэмцээний төлөвлөгөөний дагуу 21 их, дээд сургууль болон дунд сургуулиудад хамтран ажиллах санал тавьсан бөгөөд орчлон сургуулийн сурагчид тэмцээнд бүртгүүлсэн. Цар тахлаас шалтгаалан тэмцээнд оролцох боломжгүй болов.</p>	<p>1. ICDL шалгалтыг 2 удаа зохион байгуулж 20 хүртэлх шалгуулагч хамруулсан байна.</p> <p>2. Олон улсын байгууллагатай хамтран маркетингийн үйл ажиллагааг сайжруулах ажлын хүрээнд 1-2 сургалт, семинар, арга хэмжээ зохион байгуулж 100-120 хүн хамруулсан байна.</p>	100
2.1.3.	ТОПСИТ бэлтгэл ажиллагааг хангах, зохион байгуулах, тайлагнах, хамтын ажиллагаа өрнүүлэх	ТУСМХ	<p>1. ТОПСИТ шалгалтыг 1 удаа зохион байгуулж, 9 шалгуулагч хамрагдсан. 2 дахь удаагийн шалгалтыг Солонгосын ИТР байгууллагаас тавьсан хүсэлтийн дагуу 2022 онд зохион байгуулахаар болов.</p> <p>2. ТОПСИТ шалгалт танилцуулах вэбинар, семинарыг Их дээд сургуулиуд болон Аж ахуй нэгжүүдэд 5 удаа зохион байгуулж, 81 оролцогч хамруулав.</p>	<p>1. ТОПСИТ шалгалтыг 2 удаа зохион байгуулж 80 хүртэлх шалгуулагч хамруулсан байна.</p> <p>2. Олон улсын байгууллагатай хамтран маркетингийн үйл ажиллагааг сайжруулах ажлын хүрээнд 1-2 сургалт, семинар, арга хэмжээ зохион байгуулж 100-120 хүн хамруулсан байна.</p>	60
2.1.4.	Аттестачлал зохион байгуулах	ТУСМХ	Аттестатчиллын шалгалтыг Эрдэнэс Таван толгой ХК, Инкубаторын компани болон Steppe holding ХХК -ийн ажилтнуудыг хамруулан 2 удаа зохион байгуулж, 19 шалгуулагч хамруулсан. Шалгалтаас гарсан үр дүнг байгууллага тус бүрт танилцуулан, санал зөвлөмж өгөв.	Үндэсний шалгалтын системийн суурийг тавих зорилгоор төрийн болон төрийн өмчит ААН, бизнес эрхлэгч байгууллагуудтай хамтран МТ-ийн аттестатчиллын шалгалт зохион байгуулах боломжийг судлан 1-2 байгууллагатай хамтран шалгалт зохион байгуулсан байна.	100

		2.1.5.	Холбогдох бичиг баримтыг боловсруулах, шинэчлэх, хөтлөлт хийх	ТУСМХ	Ур чадварын шалгалтын журам, Сургагч багш бэлтгэх сургалтын журмуудыг шинээр гаргасан бол МТИШ-ын журам, ТОПСИТ шалгалтын журмуудыг шинэчлэв. Мөн 4 бүлэг бүхий шалгалт, сургалтын гарын авлага гаргав.	Дүрэм, журам, гэрээ болон бусад бичиг баримтыг цаг тухайд нь гарган хэрэгжүүлсэн байна.	100
2.2	Гадаад, дотоод сургалтын үйл ажиллагааг зохион байгуулах	2.2.1	Мэдээллийн технологийн мэргэжлийн болон мэргэшүүлэх ур чадварын сургалтуудыг зохион байгуулах	ТУСМХ	МТИШ-ын сургагч багш бэлтгэх сургалтад 4, iDeveloper сургалтад 1 ажилтан тус тус хамрагдаж гэрчилгээ авсан.	Байгууллагын ажилчдын ур чадварыг нэмэгдүүлэх, мэргэжлийн сургалтыг зохион байгуулж 5-аас доошгүй ажилтныг хамруулан гэрчилгээ олгосон байна.	100
				ТУСМХ	1. МУ-д МТ-ийн чиглэлээр сургалтын үйл ажиллагаа явуулдаг 20 сургалтын төвийн 58 нэр төрлийн сургалтыг харьцуулсан судалгаа болон Дэлхийд эрэлттэй 10 сургалтын дэлгэрэнгүй судалгааг хийв. Судалгаанд дүн шинжилгээ хийхэд МТ-ийн чиглэлийн бус хүмүүст зориулсан богино хугацааны "МТ-ийн мэргэшил эзэмшүүлэх" сургалт хамгийн их эрэлттэй байсан бол Сүлжээ, аюулгүй байдал, өгөгдлийн сан, Tableau desktop, систем админ, MySQL гэсэн сургалтууд хамгийн эрэлттэй байв. 2. Судалгааны үр дүнд үндэслэн өгөгдлийн сан, Tableau desktop, систем админ, MySQL сургалтуудыг нийт 3 удаа зохион байгуулж, 14 суралцагч хамрагдав. 3. Япон улсын Гадаадтай үүсгэх техникийн хамтын ажиллагааны нийгэмлэг /AOTS/ -тэй хамтран "Сургагч багш бэлтгэх сургалт"-ыг зохион байгуулав. Сургалтад Улаанбаатар хот болон хөдөө орон нутгийн шаардлага хангасан 50 оролцогч хамрагдсан бөгөөд ОУ-д хүлээн зөвшөөрөгдсөн "Сургагч багш"-ийн гэрчилгээг олгов.	МТ-ийн мэргэшүүлэх сургалтанд дүн шинжилгээ хийх, эрэлттэй сургалтыг тодорхойлох, тооноос чанарыг эрхэмлэн 5-9 төрлийн сургалтыг зохион байгуулж 50-80 хүнийг хамруулан мэргэшүүлэх гэрчилгээ олгосон байна.	100
				ТУСМХ	1.Сургалтын судалгаанд үндэслэн Инно плас ХХК-тай хамтран "iDeveloper"сургалтын хөтөлбөр боловсруулсан бөгөөд МТ-ийн мэргэжлийн бус хүмүүс 7 сарын хугацаанд компьютерын ухаан, мобайл апп, веб хөгжүүлэлт, япон хэл болон МТИШ-д бэлтгэх сургалтад хамрагдаж, улмаар энэ чиглэлээр ажиллах боломжтой юм. "iDeveloper" сургалтад 20 суралцагч хамрагдаж байгаа бөгөөд 2022 оны 7 сард дуусна. 2. "Багшийн мэргэжил дээшлүүлэх институт (БМДИ)-ийн онлайн сургалтын платформ"-ийг хэрэглээнд нэвтрүүлэх 2 удаагийн сургалтыг зохион байгуулж, 383 суралцагч хамруулав.	Шинээр ур чадварын сургалтыг 2-3 удаа зохион байгуулж, 10-15 хүн хамруулж гэрчилгээ олгосон байна.	100
				ТУСМХ	ФИБО КЛАУД ЭДҮКЭЙШН ЦЕНТР ХХК -тай хамтран "AWS Solutions Architect Associate", "Certified Kubernetes Administrator (СКА)" сэдэвт 2 удаагийн сургалтыг зохион байгуулав. Сургалтад	Гадаад болон дотоодын байгууллага, их дээд сургуультай хамтран сургалт зохион байгуулсан байна.	100

				хамрагдагчдын тоо: 17			
			ТУСМХ	Монголын сансрын технологийн холбоотой (МОСТА) Space academy байгуулах гэрээ байгуулж, сургалтын үйл ажиллагааг Эмбеддэд системийн лабораторийн бааз суурийг ашиглан эхлүүлсэн бөгөөд "Scratch", "SPACE академи" нэртэй 2 удаагийн сургалтыг зохион байгуулж, 27 суралцагч хамруулав. Нийт 1.4 сая төгрөгийн орлого татан төвлөрүүлсэн. 2022 оны эхнээс HTML & CSS-ийн сургалтыг bootcamp хэлбэрээр зохион байгуулахаар төлөвлөж байна.	Өсвөрийн инженерийн сургалтыг жилд 2 удаа зохион байгуулж 30-40 хүн хамруулсан байна.	95	
	2.2.2	Холбогдох бичиг баримтыг боловсруулах, шинэчлэх, хөтлөлт хийх	ТУСМХ	1. Сургалтын төвийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг сэргээж, гэрчилгээг шинээр авав. Хугацаа 2023 оны 7 сарын 09-ний өдөр дуусна. 2. Сургалтын хүрээнд Articulate 360 системийн 3 гарын авлага, Canvas LMS системийн 3 гарын авлага, Rice 360 болон Цахим сургалтын арга зүй гэх мэт нийт 8 гарын авлага боловсруулан, төслийн сургалтуудад ашиглаж байна.	Дүрэм, журам, гэрээ болон бусад бичиг баримтыг цаг тухайд нь гарган хэрэгжүүлсэн байна.	100	
2.3	Дотоод хүний нөөцийн ур чадварыг хөгжүүлэх	2.3.1	Байгууллагын ажилчдын ур чадварыг нэмэгдүүлэх, мэргэжлийн сургалт, байгууллагын соёл болон ёс зүйн сургалтыг тус бүр 5-аас доошгүй зохион байгуулах	ЗУХ	1. Ажилчдын ур чадварыг нэмэгдүүлэх чиглэлээр Төслийн менежмент сэдэвт сургалтад -24, Илтгэх урлаг сэдэвт сургалтад -23, Инновацийн хууль тогтоомжийн хэрэглээ сэдэвт сургалтад -15, Албан бичиг төлөвлөлтийн сургалтад -17, Баримт, бичих архивлах сургалтад -15, Design thinking-brainstorming workshop -7 албан хаагч тус тус хамруулсан. 2. Ёс зүй, харилцааны чиглэлээр Ажлаас халшрах өвчлөл сэдэвт сургалтад- 30, Стресс менежмент сэдэвт сургалтад -28 албан хаагч хамруулж нийт 8 сургалтад давхардсан тоогоор 160 ажилтан, албан хаагч хамруулав. "Монгол бичгээр уншиж, бичиж сурцгаая сургалтыг намжилттай зохион байгуулсан. Оролцогчдын хувьд эгшиг, гийгүүлэгч үсгээ үзэж дууссан байна.	Байгууллагын ажилчдын ур чадварыг нэмэгдүүлэх, мэргэжлийн сургалт, байгууллагын соёл болон ёс зүйн сургалтыг тус бүр 5-аас доошгүй зохион байгуулан сургалтанд хамруулсан байна. ЗГ-ын 2020 оны 96-р тогтоолын хэрэгжилтийн хангах ажлын хүрээнд холбогдох сургалтыг зохион байгуулах. /Үндэсний Монгол бичгийн хичээл ажилчдад оруулах/	100

		2.3.2	Ажилчдын мэргэжил боловсролыг дээшлүүлэх чиглэлээр гадаад болон дотоодын урт, богино хугацааны сургалт, семинарт хамруулах	<p>1. Ажилчдын мэргэжил боловсролыг дээшлүүлэх чиглэлээр Цэгцтэй сэтгэх арга сургалт -3, Гарааны бизнес ба оюуны өмч сэдэвт сургалт - 3, Систем админы сургалт -1, Архив албан хэрэг хөтлөлтийн сургалтад -1, iDeveloper сургалтад 2, Хөдөлмөрийн аюулгүй байдлын сургалт -1, МТИШ-ын сургагч багш бэлтгэх сургалт -4, Оюуны өмчийн хууль,технологи дамжуулах сургалт -3, Оюуны өмчийн интерактив сургалт -5, Сошиал маркетингийн сургалтад- 3 нийт 26 ажилтан дотоодын богино хугацаат сургалтуудад хамрагдсан бол Докторт 2, магистрт 2 ажилтан суралцаж байна.</p> <p>2. МТИШ-ын паспорт шалгалтад Программ хангамжийн инженер Г.Санчир, МТ-ийн мэргэжилтэн О.Батсүрэн, Сошиал медиа хариуцсан мэргэжилтэн А.Амартөгс нарыг оролцуулсан.</p>	Дотоодын үйл ажиллагаанд 7-оос доошгүй ажилтан, гадаадын үйл ажиллагаанд 3-аас доошгүй ажилтан хамруулсан байна.	100	
3	Судалгаа, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх үйл ажиллагаа						
3.1	Гарааны бизнес хөгжүүлэх, үйл ажиллагааг хөгжүүлэх	3.1.1.	Компаниудын бүтээгдэхүүн үйлчилгээг зах зээлд нэвтрүүлэх, холбогдох салбарт зуучлах ажлыг судлах, гүйцэтгэх, инкубаторын зорилтот салбарыг тодорхойлох	ТУСМХ	1. "Төрийн худалдан авалт-Үндэсний үйлдвэрлэл 2021" үзэсгэлэнд инкубаторын 2 компанийн бүтээгдэхүүн, үйлчилгээг танилцуулав. 2. Япон-Монголын эдийн засгийн түншлэлийн 5 жилийн ойн үзэсгэлэнд СИМ ХХК-ийг онлайнаар оролцуулав.	Холбогдох салбарт 2-3 компанийн бүтээгдэхүүн, үйлчилгээг зуучлах ажлыг зохион байгуулсан байна.	100
				ТУСМХ	Юмсын интернэт (IoT), эмбеддэд системийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг зорилтот салбарын 41 дэх (ахисан түвшний инкубатор) удаагийн элсэлтэд 1 компани оролцсоноос 1 компани сонгон шалгаруулалтад тэнцэж инкубаторт элсэв.	Инкубаторын компаниудын үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийж шаардлагатай зорилтот салбарыг тодорхойлон 1 удаа элсэлт зарласан байна.	100
				ТУСМХ, ИТСХХ	1. Жайка-аас хэрэгжүүлж буй "Шинэ Зуунмод" төслийн судалгааны санал авах хэлэлцүүлэгт хамтран ажиллах саналыг инкубатор болон хаабын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 10 байгууллагуу цахимаар илгээсэн. 2. "Ай Ти Ти Өү" ХХК технологи дамжуулах төвтэй хамтран "Оюуны өмчийн интерактив" сургалтыг зохион байгуулав.	Гарааны бизнесийн төвлөрлийг үүсгэх, хамтран ажиллах судалгааг гаргаж, ижил төстэй үйл ажиллагаа эрхэлдэг 3-4 байгууллагатай хамтран ажиллах гэрээ байгуулсан байна.	50

3.1.2.	Мэдээллийн нэгдсэн санг хөгжүүлэх	ТУСМХ	<p>1. Нийт 29 төрлийн 995 монгол аппликейшн, 323 хөгжүүлэгчдийн судалгааг өргөжүүлэн мэдээллийн бааз үүсгэв. Үүнд: education, business, finance гэсэн 3 ангилалд хамгийн их аппликейшн хөгжүүлэгдсэн байна. Өмнөх онтой харьцуулахад аппликейшний тоо 87, хөгжүүлэгчдийн тоо 6-аар нэмэгдсэн байна.</p> <p>2. Мэдээллийн технологийн инкубаторын 2003-2021 оны мэдээллийн сангийн статистикийг шинэчлэн гаргав. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Сонгон шалгаруулалтад оролцсон 373, тэнцсэн 144 - Төгсөгчдөөс үйл ажиллагаа нь зогссон 74, үргэлжлүүлж байгаа 55 - Амжилттай төгсөгч 48, Шилдэг төгсөгч 13 - Хасагдсан 41, Хугацаанаас өмнө төгссөн 28 <p>3. 2006-2021 оны хүртэлх сургалтын статистик мэдээллийг гаргасан бөгөөд нийт 39 төрлийн сургалтад 2248 суралцагч хамрагдсанаас 2021 онд 9 төрлийн сургалтад 513 суралцагч хамрагдсан байна.</p>	Салбарын нэгдсэн мэдээллийн сангийн хөгжүүлэлтийг тогтмол хийн судалгаанд ашиглагдсан байна.	100
3.2.1.	Салбарын хүний нөөцийн судалгаа хийн нэгдсэн мэдээллийн санг үүсгэх	ТУСМХ	ХХМТГ-тай хамтран "Мэдээллийн технологийн салбарын хүний нөөцийн мэдээллийн сан"-г үүсгэхэд 341 байгууллагатай утсаар холбогдож, судалгааг бөглүүлэх болон бусад ажлыг гүйцэтгэв. Мэдээллийн сангийн нэгтгэлийг ХХМТГ-т хариуцаж байна.	Салбарын хүний нөөцийн мэдлэг ур чадварыг нэгдсэн судалгаа гаргаж, шаардлагатай чиглэлээр сургалт, уулзалт, семинарыг 1 удаа зохион байгуулсан байна.	50
3.2.2.	Салбар дундын үйлчилгээг технологитой холбосон гарааны бизнесийг дэмжин ажиллах .	ТУСМХ	<p>1. Байгууллагын хүрээнд цахим байгаль төслөөр 1 интрапренёр төгсгөж, "Toblo" төслөөр 1 интрапренёр шинээр төрүүлэн гаргав.</p> <p>2. Цахим байгаль төслийн бүтээгдэхүүн үйлчилгээг зах зээлд таниулах чиглэлээр ОУ-ын цахим үзэсгэлэнд 1 удаа, бизнес хөгжүүлэх болон хөрөнгө оруулалт татах арга хэмжээнд 3 удаа оролцуулж, дэмжлэг үзүүлэн ажилласны үр дүнд Харилцаа холбооны салбарын 100 жилийн ойн хүрээнд зохион байгуулагдсан эрлэм шинжилгээний хурлын "шилдэг өгүүлэл" номинацид тэргүүн байр эзэлсэн.</p>	<p>1. Интрапренёр шинэ үйлчилгээг нэвтрүүлж, 1 бүтээгдэхүүн үйлчилгээг зах зээлд таниулсан байна.</p> <p>2. Холбогдох дүрэм, журам гарган хэрэгжүүлсэн байна.</p>	100

3.2

Салбарын болон салбар дундын судалгаа, төсөл хөтөлбөр хийх

		3.2.3.	ХХМТГ-т газарт 2020 онд хүргүүлсэн төслийн бэлтгэл ажлыг хангах	ТУСМХ	<p>1. R&D төслийн танилцуулгыг англи хэл рүү хөрвүүлсэн бөгөөд төслийг хэрэгжүүлэх чиглэлээр хамтран ажиллах байгууллага болон хөрөнгө оруулалт татах боломжийг судалж байна.</p> <p>2. "Эдийн засгийн хүндрэлийн үед боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах" CS-01 төсөл дээр МТҮП нь Старсофт ХХК-ийн түншлэгч байгууллагаар ажиллаж байна. Төслийн хүрээнд 3 төрлийн сургалт зохион байгуулж байгаа бөгөөд төслийн үр дүн 2022 оны 2 сард гарна.</p> <p>3. "Тэтгэлэгт энтрепренёр", "Дарханы МТ-ийн кампус", "МАБ-ын сургалт" гэсэн 3 төслийг санаачлан боловсруулав. Тус төслүүдийг хэрэгжүүлэхээр хамтран ажиллах байгууллага болон хөрөнгө оруулалт татах боломжийг судалж байна.</p>	1-2 төслийн бэлтгэл ажил бүрэн хангагдсан байна.	100
3.3	МТ-ийн инноваци, Оюуны өмчийн судалгаа	3.3.1	Инкубаторын компаниудын оюуны өмчийн судалгаа хийх, мэдээлэх, зөвлөгөө өгөх бусад арга хэмжээ зохион байгуулах	ИТСХХ, ТУСМХ	<p>Оюуны өмчийн 2 удаагийн сургалт, 3 удаагийн зөвлөгөөг инкубаторын компани, гарааны компани болон энтрепренёруудад зориулан зохион байгуулав. Үүнд:</p> <p>Сургалт:</p> <p>- Оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчтэй хамтран Оюуны өмчийн сургалт, өргөн хүрээний интерактив сургалтыг 2 удаа зохион байгуулж төр, хувийн хэвшил, инкубаторын 27 байгууллагын 35 хүн оролцов. Сургалтыг оюуны өмчийн болон үнэлгээний мэргэшсэн 7 сургагч багш сургалтыг зохион байгуулав.</p> <p>Зөвлөгөө:</p> <p>- Инкубаторын СИМ ХХК, Зэвтроник ХХК, ПТС ХХК зэрэг 3 компаниудад оюуны өмчийн мэдээлэл, зөвлөгөө өгөв.</p>	Гарааны компаниудад бүтээгдэхүүн үйлчилгээгээ оновчтой тодорхойлох боломж бүрдүүлэх зорилгоор гарааны компаниудад оюуны өмчийн мэдээлэл, зөвлөгөө өгч сургалтыг нийт 6 удаа зохион байгуулсан байна.	85
				ТУСМХ	<p>Шинжлэх ухааны академитай байгуулсан хамтын ажиллагааны хүрээнд "Технологи, инновацийн дэлгүүр"-ийг байгуулан 6-р сарын 15-аас үйл ажиллагааг нь эхлүүлэв.</p> <p>Тус дэлгүүрт Биологийн хүрээлэнгийн 4, Геологийн хүрээлэнгийн 13, Физикийн хүрээлэнгийн 5, Ботаникийн цэцэрлэгт хүрээлэнгийн 4, Тэргүүлэгчийн газрын 2, Гарааны 2 компани, МТҮП гэх 31 хүрээлэн, байгууллагын 66 нэр төрлийн бүтээгдэхүүнийг борлуулж байна.</p>	1-2 компанийн бүтээгдэхүүн үйлчилгээг инновацийн үйл ажиллагааны арга хэмжээнд танилцуулга хийж олон нийтийн хүртээл болгосон байна.	100

				ИТСХХ	Дараа үеийн хөдөлгөөнт холбооны 5 дахь үеийн системийн туршилтад оролцох хүмүүс, байгууллагын нэрс гаргахаар инкубаторуудаас санал авсан бөгөөд Сим ХХК оролцох хүсэлтэйгээ илэрхийлсэн. Оролцох хүмүүсийн нэр, холбогдох мэдээллийг илгээсэн.		
4	Гадаад, дотоод хамтарсан үйл ажиллагаа						
4.1	Гадаад хамтын ажиллагаа	4.1.1.	Гадаад, дотоод ижил төстэй байгууллагуудтай харилцан ашигтай хамтын ажиллагаа өрнүүлэх	ТУСМХ	Гадаад хамтын ажиллагаатай болон донор байгууллагуудтай хамтын ажиллагаа өрнүүлэх чиглэлээр дараах ажлыг хэрэгжүүлэв. Үүнд; 1. Япон улсын IPPEC байгууллагатай хамтран МТИШ-ыг 2 удаа, шалгалт танилцуулах семинарыг 1 удаа, ОУ-ын асуулт боловсруулагчдын уулзалтыг 2 удаа, гишүүн орнуудын удирдлагуудын уулзалтыг 1 удаа 2. Япон улсын AOTS байгууллагатай хамтран сургагч багш бэлтгэх сургалтыг 2 удаа 3. БНХАУ-ын Huawei компанитай хэлэлцээр хийн хамтын ажиллагаа үүсгэж, 20 ширхэг Ideahub ухаалаг дэлгэцийг хүлээн авав. 4. Азийн шинжлэх ухааны паркуудын холбооны ээлжит хурал болон "SCIENCEPARK INNOFAIR-2021" форумд байгууллагаа танилцуулан оролцов. 5. Startup World Cup 2021 Mongolia бүсийн арга хэмжээний Government түншлэгчээр оролцож, Захирал Э.Цогтгэрэл Startup World Cup-ийн шүүгчээр ажиллалаа. 6. Солонгосын ITP байгууллагатай хамтран ТОПСИТ шалгалтыг 1 удаа, Сингапурын ECDL байгууллагатай хамтран ICDL шалгалтыг 1 удаа 7. Мэдээллийн технологийн үндэсний парк (МТҮП) нь энэ жилийн Founder Institute Mongolia-ийн Government түншлэгчээр хамтран ажиллав.	Хамтын ажиллагаатай болон донор байгууллагуудтай хамтын ажиллагаа өрнүүлсэн байна.	100
				ТУСМХ	ОУ-ын хурал, зөвлөгөөн, арга хэмжээнд албан хаагчдыг хамруулах ажлын хүрээнд IPPEC-ийн гишүүн орнуудын удирдлагуудын уулзалтад 3, ОУ-ын асуулт боловсруулагчдын уулзалтад 1, Азийн шинжлэх ухааны холбооны онлайн уулзалтад 2, Дэлхийн оюуны өмчийн газрын хуралд 1 нийт 7 албан хаагч хамруулав.	Олон улсын хурал, зөвлөгөөн, арга хэмжээнд байгууллагаас 3-4 ажилтан оролцуулсан байна.	100
				ТУСМХ	Инкубаторын компаниудын бүтээгдэхүүн үйлчилгээ, хүний нөөцийн ур	ХХААХҮЯ-ны Дэлхийн банктай хамтран хэрэгжүүлж буй "Шинэлэг шийдэл" хөтөлбөрийн танилцуулга семинарт инкубаторын 5 компанийг хамруулав.	Инкубаторын компаниудыг гадаад зах зээл таниулах, төсөл хөтөлбөрт хамруулах чиглэлээр ажилласан байна.

		чадварыг чадавхжуулах, олон улсын төсөл хөтөлбөрт хамруулах	ТУСМХ	Дэлхийн банкнаас мэдээлэл технологийн компаниудад зориулсан "Технологийн бизнес кластер хамтын ажиллагаа" сэдэвт сургалт, харилцаа холбоо үүсгэх арга хэмжээнд инкубаторын 5 компанийг хамруулав.	Олон улсын хурал, зөвлөгөөн, арга хэмжээнд инкубатораас 1-2 компани оролцуулсан байна.	100
			ИТСХХ, ТУСМХ	СИМ ХХК-ийн "Бионик-Электрон протек" төслийг боловсруулж, 3 байгууллагад төслийн танилцуулав. Үүнд: 1. ХНХЯ-д танилцуулсан ба холбогдох бусад байгууллагуудтай холбож өгөхөөр болсон. 2. Норвегийн тусламжийн байгууллагад танилцуулж хамтран ажиллахаар болов. 3. ASPA-ийн "SCIENCEPARK INNOFAIR-2021" үзэсгэлэнд танилцуулга хийж, үзэсгэлэнд оролцож буй компаниудтай хамтран ажиллах санал тавихаар бэлтгэв.	Донор байгууллагад инкубаторын 1-2 компанийг зуучлах, хамтын ажиллагааг эхлүүлэх бэлтгэл ажиллагааг хангасан байна.	100
	4.1.3.	Байгууллагын бичиг баримтыг гадаад харилцааны үйл ажиллагаанд бэлтгэх	ТУСМХ	Гадаад харилцааны хүрээнд ашиглаж буй албан бланк, ажилтнуудын нэрийн хуудас, байгууллагын танилцуулга зэргийг англи хэл дээр орчуулан байгууллагын хэрэгцээнд ашиглав.	Албан бланк, нэрийн хуудас, вэб, зорилтот түвшин, байгууллагын танилцуулга гэх мэт үйл ажиллагааны бүх чиглэлийн баримт бичгийг стандартад нийцүүлэн англи хэл дээр бэлтгэн гаргасан байна.	100
5	Маркетинг, олон нийттэй харилцах үйл ажиллагаа					
5.1	Байгууллагын үйл ажиллагааг чиглэл тус бүрээр олон нийтэд таниулах, нэр хүндийг өсгөх, танхим ашиглалтыг сайжруулах	Маркетингийн бодлого, төлөвлөгөө гаргах	ТУСМХ	Инкубатор компаниудын бүтээгдэхүүн үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах ажлын төлөвлөгөө, Байгууллагын үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах ажлын төлөвлөгөө, Инновацийн дэлгүүрийн бүтээгдэхүүнийг олон нийтэд хүргэх ажлын төлөвлөгөө гэсэн 3 төрлийн төлөвлөгөөг гарган хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	Маркетингийн бодлого боловсруулах, ажлын чиглэл бүрээр төлөвлөгөө гарган ажиллах, үйл ажиллагааг өргөжүүлэх ажлуудыг хэрэгжүүлсэн байна.	90
			ТУСМХ	1. Инкубаторын компаниуд, Шалгалт, Сургалтын танилцуулгыг үүдний зар сурталчилгааны зурагтад тогтмол байршуулав. 2. Инкубатор 14 компани, МТҮП-д үйл ажиллагаа явуулж буй-26 байгууллагыг нэгдсэн хаягжилттай болгов. 3. Инновацын дэлгүүрийн фэйсбүүк хуудсыг шинээр нээж нийт 21 бүтээгдэхүүний мэдээлэл нийтлэв. Дагагчдын тоо:345 4. Сар бүр онцлох үйл явдлын мэдээлэл бэлтгэн олон нийтэд хүргэж байна.	Байгууллагын болон инкубатор компаниудын бүтээгдэхүүн, үйлчилгээг олон нийтэд сард 1 удаа жилд 12 удаа сурталчилсан байна.	100
			ТУСМХ	"Аймар санаа" болон "Tirru Top" контентын байгууллагын үйл ажиллагааг сурталчлан хамтран ажиллав. Мөн "C Channel" телевизтэй хамтран "Монголын технологид суурилсан инноваци" сэдвийн хүрээнд ярилцлага зохион байгуулж, инкубаторын Urtech компанийг төлөөлөл, МТҮП-ын	Хэвлэл мэдээллийн 2-3 байгууллагатай хамтын ажиллагаа өрнүүлж, үйл ажиллагааг сурталчилсан байна.	100

			Захирлын ярилцлага зэргийг зохион байгууллаа.		
		ТУСМХ	<p>1. facebook хуудас дагагчдын тоо 2046 -аар буюу 9.5%-иар нэмэгдэж 21,502 болсон бол instagram хуудас дагагчдын тоо 34-өөр буюу 60%-иар нэмэгдэж 57 болсон.</p> <p>2. Байгууллагын цахим хуудсыг баяжуулах, мэдээ мэдээллийг нийтлэх ажлын хүрээнд: - facebook хуудсаар: Шалгалт-22, Сургалт-20, Инкубатор-18, Бусад- 51 - instagram хуудсаар: Шалгалт-14, Сургалт-9, Инкубатор-22, Бусад-15 - МТҮП-ын цахим хуудсаар: Шалгалт- 25, Сургалт-23, Инкубатор-24, Бусад-51 Дундаж хандалтын тоо 245,803, Давхардсан тоо 398,250 байна. 2021 онд нийтлэгдсэн мэдээллийн тоо 115-аар нэмэгдэж 224, хандалтын тоо 74,582-оор нэмэгдэж 320,385 болсон.</p> <p>3. Үнэ цэнтэй контент гаргах ажлын хүрээнд: - Инкубатор компаниудыг хамруулсан "Бидний мэдэх Ай Ти Парк", - "Мэдээлэл, технологийн үндэсний паркын жилийн онцлох мэдээлэл", - "МТҮП-д инкубатораар элсэн орсны давуу тал" гэсэн сэдвүүдээр 3 контент гаргаж олны хүртээл болгов. - МТҮП-ын нэрэмжит туршилтын подкастыг 2 удаа зохион байгуулав. - Шалгалт, сургалтын агуулгыг шинэчлэн контент гаргахад бэлтгэв.</p>	Сошиал орчны үйл ажиллагааг эрчимжүүлж, дагагчдын тоог 20-30 хувиар нэмэгдүүлж, үнэ цэнэтэй контентуудыг гарган олны хүртээл болгосон байна.	100
		ТУСМХ	"Digital nation 2021" үзэсгэлэн, арга хэмжээнд инкубаторын компаниудтай хамтран оролцож, бүтээгдэхүүн, үйлчилгээг танилцуулав. Арга хэмжээний мэдээллийг News.mn, Ikon.mn, Eguur.mn, focus.mn сайтуудаар түгээв.	Технологийн үзэсгэлэн арга хэмжээнд 1-2 удаа оролцож, зохион байгуулсан байна.	100
		ТУСМХ	Байгууллагын брэнд бүтээгдэхүүний санал, төлөвлөгөө, төсөв гарган батлуулав.	Байгууллагын брэнд бүтээгдэхүүн гаргах, хэвлүүлэх	50
5.1.2.	Танхимуудын ашиглалтыг сайжруулах	ТУСМХ	302, 303 тоот танхимуудад нийт 6 удаагийн 38 цагийн түрээсээр 4,120.000 төгрөгийн орлого оруулсан. Үндсэн үйл ажиллагаа болон хамтын ажиллагааны хүрээнд сургалт, шалгалт, семинар гэх мэт 15 арга хэмжээ зохион байгуулагдсан байна. Хамтарсан болон түрээсийн үйл ажиллагааны хүрээнд зохион байгуулсан арга хэмжээнүүдэд нийт 400 гаруй хүн хамрагдсан байна.	302 болон 303 тоот сургалтын танхимуудын ашиглалтыг нэмэгдүүлж өмнөх оноос 5 хувиар ахиулсан байна.	100

			ИТСХХ	211, 217 танхимуудад нийт 10 удаагийн 49 цагийн түрээсээр 5,539.000 төгрөгийн орлого оруулсан. Үндсэн үйл ажиллагаа болон хамтын ажиллагааны хүрээнд сургалт, шалгалт, семинар гэх мэт 11 арга хэмжээ зохион байгуулагдсан байна. Хамтарсан болон түрээсийн үйл ажиллагааны хүрээнд зохион байгуулсан арга хэмжээнүүдэд нийт 350 гаруй хүн хамрагдсан байна.	210 болон 211-ийн ашиглалтын сайжруулж өмнөх оноос 10 хувиар ахиулсан байна	100	
6	Техник, программ хангамж, серверийн үйл ажиллагаа						
6.1	Техник, программ хангамж, холбооны хэвийн ажиллагааг хангах	6.1.1.	Байгууллагын цахим хуудас болон ERP системийн хэвийн үйл ажиллагааг хангаж ажиллах	ИТСХХ	Байгууллагын цахим хуудас шинэчлэх, үйл ажиллагааг хэвийн явуулах чиглэлээр дараах ажлыг хийж гүйцэтгэв. Үүнд: 1. Цахим хуудасны агуулга, мэдээллийг шинэчлэн вэбсайтын backup хийв. 2. Вэбсайтын мэдээллүүдэд анализ хийн, 2003-2012 оны хоорондох 285 мэдээг архиваас оруулсан. 3. Цахим хуудасны шинэ загварыг худалдан авч, database-г холбох ажил явагдаж байна. 4. <u>Incubator.itpark.mn</u> -ий хувьд laravel болон angular хэл хольж бичигдсэн өгөгдөл нь SQL-ийн 2-3 төрлийн программтай холбогдож ажилладаг учир засвар хийхэд зарим функцүүд, програмчлалын хэлийг ойлгохгүй байх асуудал тулгарч байна. 5. SSL certificate худалдан авч, сервертээ суулгасан. Серверийн үйлдлийн систем хуучирсны улмаас protocol -оо дуудаж ажиллаж чадахгүй байна. Веб серверийг шинэчлэх талаар судалгаа хийж байгаа бөгөөд тохируулга хийж, шаардлагатай программыг суулгасан. 6. Албан хаагчдын и-мэйл тохируулга, нууц үг солих үйлчилгээг нийт 85 удаа хийсэн бөгөөд 12 и-мэйл хаягийг чиглэл бүрээр шинээр үүсгэж хариуцсан ажилтнуудад өгсөн.	Байгууллагын цахим хуудас болон ERP системийг 100 хувь ажиллагаатай болгож, цаасгүй технологийг нэвтрүүлэгч байгууллага болсон байна.	100

		Сүлжээ, холбооны хэвийн ажиллагааг ханган ажиллах	ИТСХХ	<p>Сүлжээний хэвийн ажиллагааг хангах чиглэлээр дараах ажлын хийж гүйцэтгэв. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Ситинет ХХК-тай гэрээ байгуулж, 80mb хурдаар интернэт үйлчилгээг авч байна. Интернэтийн үйлчилгээ авч буй компани солигдсонтой холбоотойгоор шилэн кабель шинээр татан, ISP сольж, тест хийв. 2. 4-р давхрын 2 өрөө, 2-р давхрын 8 өрөө, 1-р давхрын 1 өрөө, 3-р давхрын 1 өрөө нийт 12 өрөөнд сүлжээний доголдол үүссэнийг засварлав. Мөн Хууль зүйн туслалцааны төвийн интернэт доголдсоныг засаж хэвийн ажиллагаанд оруулав. 3. Нийт 24 удаа инкубатор компаниуд болон үйл ажиллагаа эрхлэгч байгууллагуудын wifi router тохируулав. 4. 4-р давхрын 3 өрөөнд нийт 200м, 3-р давхрын 2 өрөөнд нийт 270м, 1-р давхарт 80м, серверийн өрөөнөөс 3-р давхар луу тус тус сүлжээний утас татаж холболт хийсэн. Мөн 1-р давхарт технологи инновацийн дэлгүүрт интернэт сүлжээ оруулав. 5. Тоног төхөөрөмж шинэчлэх ажлын хүрээнд серверийн өрөөнд хөргүүр, 2 давхарт 24 port-той switch төхөөрөмж, 302 танхимд 100/1000-тай switch худалдан авч, холбогдох тохируулга суурилуулалтын ажил хийв. 6. Холбоо, суурин утасны хэвийн ажиллагааг хангах чиглэлээр нийт 12 дугаарыг хүн тус бүр дээр холбож, программ дээр тохируулах, дотуур холбоог шинэчлэх зэрэг ажлыг хийж гүйцэтгэв. 	Сүлжээ, холбооны хэвийн ажиллагааг хангаж доголдолгүй ажиллах бололцоог бүрдүүлсэн байна.	100
--	--	---	-------	---	---	-----

		Техник, тоног төхөөрөмж, программ хангамжийн хэвийн ажиллагааг ханган ажиллах, шинэчлэх, засварлах	ИТСХХ	Техник тоног, төхөөрөмжийн хэвийн ажиллагааг хангах чиглэлээр дараах ажлыг хийж гүйцэтгэв. Үүнд: 1. 222 оффисын үүдний царай таних төхөөрөмж удаагийн гэмтлийг ИТСаге компанид дуудлага өгч хамтран засварлав. 2. 302,303,217,211 тоот танхим зохион байгуулагдсан түрээсийн 16, хамтын ажиллагааны болон үндсэн үйл ажиллагааны хүрээнд зохион байгуулагдсан нийт 26 арга хэмжээний техник, тоног төхөөрөмжийн хэвийн найдвартай ажиллагааг ханган ажиллалаа. 3. Үйл ажиллагааны хүрээнд хандиваар ирсэн ухаалаг дэлгэцүүдийг техникийн шаардлагын дагуу хүлээн авч, угсрах, шаардлагатай танхимуудад байрлуулж хэвийн ажиллагааг нь ханган ажиллаж байна. 4. Хяналтын камеруудын хэвийн ажиллагааг хангах чиглэлээр 1-р давхарт 2, 3-р давхрын 3, 2-р давхарт 2 нийт 7 камер суурилуулж, 1 NVR дээр хард диск танихгүй байсныг таниулж шинээр камеруудыг тохируулсан. 5. Албан хаагчдын техник хэрэгслийн хэвийн ажиллагааг хангах чиглэлээр давхардсан тоогоор 14 ажилтанд оффисын программ суулгав. 6. Дотоод үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа 5 принтерийн хэвийн ажиллагааг ханган, гарсан гэмтлийг засварлуулж ажиллалаа.	Шаардлагатай тоног төхөөрөмжийн шинэчилсэн байна.	100	
7	Удирдлагын оновчтой бодлого, төлөвлөлтийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа						
7.1	Хууль эрх зүйн хүрээнд байгууллагын эрх ашгийг хамгаалах	7.1.1	Хууль эрх зүйн маргаантай асуудлыг шийдвэрлэхэд байгууллагын эрх ашгийг хамгаалан ажиллах	ЗУХ	1. Нийт 28 иргэн, ААН-ээс нийт 94,261,346 сая төгрөгийн авлага барагдуулахаас 8 аж ахуйн нэгжийн 8,340,184 төгрөгийн авлагыг барагдуулсан. 2. Улсын дээд шүүх 2021.03.23-ний өдрийн 001/ХТ2021/00254 дугаар тогтоолоор Сүхбаатар дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2019.06.19-ний өдрийн 181/ШШ2019/01391 дугаар шийдвэрийг хэвээр үлдээсэн. Тус шүүхийн шийдвэрт 34,330,250 төгрөгийг МТҮП-аас гаргуулан Багэт ХХК-д олгох тухайн компаниас 4,313,308 төгрөгийг МТҮП-д олгох шийдвэрийн хэрэгжилтийг хангуулан зохион байгуулж төлбөрийн зөрүү тооцуулан барагдуулав. 3. Авлагатай 16 байгууллага байгаагаас 13 нь Иргэний хуульд заасан журмын дагуу хөөн хэлэлцэх хугацаа нь дууссан бөгөөд хуулийн байгууллагаар нэхэмжлэл үүсгэхэд хэрэгсэхгүй болох магадлал өндөр байна. Гурван байгууллагын хаяг тогтоолгохоор холбогдох хуулийн байгууллагад	Гэрээний зөрчил арилж, хуулийн хүрээнд байгууллагын эрх ашиг хамгаалагдсан байна.	100

			ажиллагаа хийлгэж байна.		
			2021.06.15-ны шөнө барилгын баруун жигүүрт гал гарсантай холбоотойгоор холбогдох байгууллагуудад мэдэгдэх, дүгнэлт гаргуулах байгууллагыг хохиролгүй болгох чиглэлээр ажилласны үр дүнд засварын бараа материалыг эзэн холбогдогчоор гаргуулахаар болсон. Мөн СБД-ийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөлд хүсэлт гарган байгууллагын байрны баруун жигүүрт стандартын шаардлага хангахуйц 2 ширхэг хяналтын камер суурилуулах ажлыг гүйцэтгүүлсэн.		
7.1.2	Дүрэм журам, гэрээ шинээр боловсруулах, шинэчлэх, хянах	ЗУХ	<p>1. Үндсэн үйл ажиллагааны хүрээнд Контрактын 1, Хөдөлмөрийн 30, Хөлсөөр ажиллах 5, Бусдаар барилгын засвар шинэчлэлтэй холбоотой ажил гүйцэтгүүлэх 2, Танхим ашиглалтын 17, Сургагч багшийн 14, Инкубаторын хөтөлбөрт хамтран ажиллах гэрээ 8, Ажиллах орчноор хангах 5, Хандивын бараа бүтээгдэхүүн нийлүүлэх 1, Бусад 5 нийт 88 гэрээний үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна.</p> <p>2. Байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдаж буй батлагдсан 13 гэрээний загварыг нэгтгэж гарын авлага гарган албан хаагчдад үйл ажиллагаандаа ашиглах боломжийг хангав.</p> <p>2. Байгууллагын үйл ажиллагаанд мөрдөгдөж буй 3 бодлогын баримт бичиг, 3 дүрэм, 21 журам бүхий хавтас гарган, ажилчдын мэдээлэл авах, үйл ажиллагаандаа ашиглах боломжийг бүрдүүлэв.</p> <p>3. Шинэ ажилтанд зориулсан гарын авлага, ажилчдын хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны зааварчилга зэрэг баримт бичгүүдийг батлуулж, эмхэтгэл гарган нээлттэй байршуулав.</p> <p>4. 2021 онд шинээр ажилтан, албан хаагчдын Сургалтын хөтөлбөр, Хүний нөөцийн бодлогын баримт бичиг, Сургагч багш бэлтгэх журам, Танхим ашиглах журам зэрэг баримт бичгүүдийг шинээр боловсруулж батлуулав.</p> <p>5. Талбай ашиглалтын 23 гэрээний хэрэгжилтийг ханган ажиллаж байна.</p>	Байгууллагын дотоод үйл ажиллагаанд болон үндсэн үйл ажиллагаанд хэрэглэгдэж буй дүрэм, журам, гэрээ зэрэг баримт бичиг шаардлагын дагуу боловсруулагдан баталгаажсан байна.	100

7.2	МТҮП-ын ашиглалт, санхүү төлөвлөлтийг сайжруулах	7.2.1	Байгууллагын байрны талбай ашиглалт, тохижилтыг сайжруулах	ЗУХ	<p>Байгууллагын байрны талбай ашиглалт, тохижилтыг сайжруулах ажлын хүрээнд дараах ажлыг хийж гүйцэтгэв. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Байгууллагуудын хаягийг нэгдүгээр давхрын дэлгэцэн дээр байршуулсан бөгөөд гадна хаягжилтыг Төрийн байгууллагын хаягийн стандартын дагуу хийлгэн байрлуулав. 2. 2 болон 4-р давхрын АЦӨ-үүдэд кабин сунгах, эвдэрсэн нэг хаалга солих, цөмөрсөн тааз засах зэрэг шаардлагатай засвар тохижилтын ажил хийв. 3. 302, 433, Сангийн ажилчдын өрөө, ИТСХХ-ийн даргын өрөөнүүдэд урсгал засвар хийв. 4. Гарденд дугуйн зогсоол байрлуулав. 5. 3-р давхрын гарденд буюу 211 дээврийн засварын ажлыг "Вертокталст" ХХК байгууллагаар гүйцэтгүүлэв. 6. Байгууллагын байрны баруун талын шитийн хаалгыг шинэчлэв. 7. Узелийн дулааны шугам хоолойг будаж, хаалга солив. 8. "Scienbiz" технологи, инновацийн дэлгүүр байгуулах ажлын хүрээнд урсгал засвар, тохижилтын ажлын хийж гүйцэтгэв. 9. Төлөвлөгөөт засварын ажил ТӨБЗГ болон СЯ-аас зардал бууруулах албан даалгавар ирсний дагуу хойшлуулсан. 	Гадна хаягжилт болон дотор хаягжилт, 1,2,4-р давхарын коридорын урсгал засвар тохижилтын ажил хийгдсэн байна.	100
				ЗУХ	<p>Мастер лифт, Белинтэ, Genaral elevator, Хөлөг элактор гэх 4 байгууллагаар хэмжилт хийлгэж 4, 5 зогсоолтойгоор үнийн санал авсан бөгөөд ТӨБЗГ болон СЯ-аас зардал хэмнэх албан даалгавар ирсний дагуу худалдан авалтыг хойшлуулж, 2022 оны зорилтот түвшинд дахин суулгав.</p>	Байгууллагын цахилгаан шатыг ажиллуулсан байна.	100
				ЗУХ	<p>Байгууллагын байрны зүүн талын буюу төв хаалга хэсгийн авто зогсоолыг төлбөртэй болгох асуудлаар Нийслэлийн авто замын хөгжлийн газар /НАЗХГ/-тай гэрээ байгуулсан бөгөөд зогсоолын систем, тоног төхөөрөмж суурилуулалтын ажлыг инкубаторт бойжиж буй СИМ ХХК -тай хамтын ажиллагааны хүрээнд гүйцэтгүүлэхээр болсон. Суурилуулалтын ажил хил, гаалийн асуудлаас удаашраад байна. Мөн байрны урд хэсэгт СИМ ХХК-ийн хэрэгжүүлж буй төслийн хүрээнд Цахилгаан авто машин цэнэглэх төхөөрөмжийн анхны хувилбарыг байршуулахаар төлөвлөн СИМ ХХК-д шаардлагатай мэдээллийг өгч ажиллалаа. 2022 оны I-р улиралд суурилуулалтын ажил хийгдэж дуусна.</p>	Авто зогсоол байгуулах	100

				ЗУХ	IT hub 1-ийн тавилга эд, хогшлыг шинэчлэн байрлуулж, ашигтай талбай гаргаж суудлын тоог нэмэгдүүллээ. Мөн цайны хэсэгт шугам татан угаалтуур гаргалаа. IT hub 2 байгуулах ажлын хүрээнд нэгдүгээр давхрын 117 тоот танхимд урсгал засвар, тохижилтын ажил хийв.	IThub-ын урсгал засвар тохижилтын ажил хийгдсэн байна.	100
